



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/44

Булган сум

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг,
байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийсэн дүнгийн тухай

Аймгийн Засаг даргын 2021 оны А/207 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын 11.1, 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 1 дүгээр байр эзэлсэн Онцгой байдлын газрыг гурав, 2 дугаар байр эзэлсэн Стандарт, хэмжил зүйн хэлтсийг хоёр, 3 дугаар байр эзэлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг нэг сая төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсугай.

2.Шагнал урамшуулалд шаардагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

3.Өргөмжлөлд шаардагдах хөрөнгийг шагналын мөнгөнөөс суутгаж олгосугай.

4.Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдалд дүгнэлт хийж, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.)

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6322011166